

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Зөрчлийн тухай хуулийг 2017 онд батлахдаа Төрийн болон албаны нууцын тухай хуульд нийцүүлэн “Төрийн болон албаны нууцын тухай хууль зөрчих” зөрчлийг хуульчилж, уг зөрчлийг Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт заасны дагуу тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтан харьяалан шийдвэрлэхээр заасан.

Зөрчлийн тухай хуулийн 15.14 дүгээр зүйлд төрийн болон албаны нууцтай холбоотой дараах зөрчилд хуулийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан:

- төрийн болон албаны нууцад хамааруулах;
- төрийн болон албаны нууцтай танилцах;
- төрийн болон албаны нууцыг нууцлах, эсхүл ил болгох;
- төрийн болон албаны нууцыг шилжүүлэх, эсхүл хамгаалах дэглэмийг хангах талаархи тогтоосон журам зөрчсөн;
- төрийн болон албаны нууцад үл хамаарах мэдээлэл нууцалсан, эсхүл хувийн зорилгоор ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

Хуулийн хэрэгжилтийн хугацаанд 23 удаагийн зөрчлийн шинжтэй үйлдэлд зөрчлийн хэрэг бүртгэлт явуулж, үүнээс 14 иргэн, албан тушаалтанд зөрчлийн шийтгэл оногдуулжээ. Үүнээс 10 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 15.14 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт заасан “төрийн болон албаны нууцыг шилжүүлэх, эсхүл хамгаалах дэглэмийг хангах талаархи тогтоосон журам зөрчсөн” үндэслэлээр шийтгэл оногдуулсан байна.

Төрийн нууцын тухай хуулийн төслийн 3.1-д “Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө” гэж, 32.4-т “Төрийн нууцад хамаарах мэдээлэл шинээр боловсруулах, шилжүүлэн авч тодорхой ажил гүйцэтгэх хуулийн этгээд нь тагнуулын байгууллагаас аюулгүй байдлын гэрчилгээ авсан байна” гэж тус тус заасан бөгөөд хуулийн этгээд өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр хуульд заасан эрх, үүргийн хүрээнд төрийн нууцын харилцаанд оролцох боломжтой юм.

Гэтэл зөрчлийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд оногдуулахаар хуульчилсан нь төрийн нууцын хууль тогтоомж зөрчсөн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх боломжийг хязгаарлаж, эрх зүйн зохицуулалтын хийдэл үүсгэж байна. Энэ нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх бодит үр нөлөөг бууруулахын зэрэгцээ шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байх хуулийн зарчмыг алдагдуулах, төрийн нууцын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хязгаарлах эрсдэлтэй. Иймд хуулийн этгээдэд зөрчлийн шийтгэл оногдуулах зохицуулалтыг бий болгох нь байгууллагын бүтэц, бодлого, удирдлагын шийдвэр зэрэг байгууллагын түвшний хүчин зүйлсээс үүдэн гардаг зөрчлийн бодит шалтгаан, нөхцөлийг харгалзан үзэх, хариуцлагыг зөвхөн хувь хүнээр хязгаарлах зохицуулалтыг сул талыг арилгах чухал ач холбогдолтой гэж үзэж байна.